

УХТЭ-ийн В гепатитийн вакцинд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны дархлаа тогтоцыг үнэлэх нь

А.Аззаяа¹, С.Анхтуяа¹,
Ц.Оюунгэрэл¹, С.Байгалмаа², Ц.Уянга³
^{1,2,3} УХТЭ

Email: ts.uyanga@yahoo.com 99828999

Үндэслэл

- Гепатит В нь гепатитын В вирусын халдвар авснаас үүсдэг элэгний өвчин бөгөөд архагшвал элэгний хатуурал, элэгний хорт хавдар, цаашид үхэлд ч хүргэж болох аюулт өвчин юм.
- В гепатитын халдвараас сэргийлэх хамгийн сайн арга бол вакцинд хамрагдах юм¹.
- Эрүүл мэндийн ажилтнууд ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалан цусаар дамжин халдварлах гепатитийн В вирусын халдварт их өртөмтгий байдаг.

- УХТЭ-ийн Халдвар хяналтын нэгжийн мэдээллийн сангийн мэдээллээр 2015 оны 05 дугаар сарын 01-ны байдлаар 397 эрүүл мэндийн ажилтны 33 (14,6%) нь В,С вирус тээгч байна. Үүний 23 (5,8%) нь В вирус тээгч, 33(8,3%) нь С вирус тээгч, 2(0,5%) нь ВС вирус тээгч байна.
- В гепатитийн халдвараас сэргийлэх стратегийн хүрээнд түс эмнэлэг дээр 2012 оноос эхлэн эрүүл мэндийн ажилтныг дархлаажуулах ажил хийгдсэн. 2015 оны 05 дугаар сарын 01 -ны байдлаар нийт дархлаажуулалтанд хамрагдвал зохих эрүүл мэндийн ажилтны 337(84,9%) нь хамрагдсан байна. Үүний 34 (9.3%) нь нэг тунгаар, 14(3,8%) нь хоёр тунгаар, 289(78,8%) нь гурван тунгаар дархлаажуулагдсан байна.²
- Нийт дархлаажуулагдсан эрүүл мэндийн ажилтныг дархлаа тогтцын талаар УХТЭ-ийн эрүүл мэндийн ажилтны дунд судалгаа хийгдэж байгаагүй тул уг судалгааг хийхээр болсон.

Судалгааны зорилго


- УХТЭ-ийн В гепатитийн вакцинд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны дархлаа тогтоцын түвшинг тодорхойлох, тунгийн тооноос дархлаа тогтоцын үр дүн хамаарах эсэхийг тодорхойлох

Зорилтууд

- УХТЭ-ийн В гепатитийн вакцинд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны дархлаа тогтоцын түвшинг тодорхойлох
- Вакцин хийлгэсэн давтамжаас дархлаа тогтоцын үр дүн хамаарч буй эсэхийг тодорхойлох юм.


Материал арга зүй

- В гепатитийн дархлаа тогтцын шинжилгээнд хамруулах зорилгоор 192 эрүүл мэндийн ажилтны цусны шинжилгээг улаан тагтай вакуумтейнерт халдварын хяналт сэргийлэлтийн дэглэмийг баримтлан авсан.
- Нас, хүйс, вакцины сүүлийн түнг хэзээ хийлгэсэн, вакцинд хэдэн удаа хамрагдсан тухай мэдээлэл дээр үндэслэн цусны шинжилгээ өгөх эрүүл мэндийн ажилтнуудыг сонгосон.
- Anti-HBs буюу В вирусын гадаргуугийн антигений эсрэг эсрэг биеийн титрийг Cobas E411 иммунологийн анализатор дээр electrochemiluminescenceimmunoassay шинжилгээний зарчмаар тодорхойлсон.




Үр дүн

- Вакцин хийлгэсэн эрүүл мэндийн ажилтны 165 (85.8%) нь дархлаа тогтсон байна.
- Цусны шинжилгээ өгсөн 192 эрүүл мэндийн ажилтнаас дархлаа тогтоогүй ($\text{anti HBs} < 10 \text{ IU/L}$) 27 (14.1%), харьцангуй дархлаа тогтсон ($\text{anti HBs} = 10-99 \text{ IU/L}$) 36 (18.8%), бүрэн дархлаа тогтсон ($\text{anti HBs} \geq 100 \text{ IU/L}$) 129 (67.2%) байна.
- 45 (23.4%) нь $\text{anti HBs} > 1000 \text{ IU/L}$ буюу маш өндөр дархлаа тогтсон байна.
- 173 нь вакцины хэдэн тун тариулсан нь мэдэгдсэн ба үүний 16 (9.2%) нь 1 тун, 9 (5.2%) нь 2 тун, 148 (85.5%) нь бүтэн 3 тунд хамрагдсан байна.



үргэлжлэл

- Вакцины 1 тун хийлгэсэн эрүүл мэндийн ажилтны 31.3%, 2 тун хийлгэсэн эрүүл мэндийн ажилтны 22.2%, бүтэн 3 тун хийлгэсэн эрүүл мэндийн ажилтны 12,8% нь anti HBs<10 IU/L буюу дархлаа тогтоогүй (anti HBs<10 IU/L) байна.
- 1 тун хийлгэсэн эрүүл мэндийн ажилтны 68,7%, 2 тун хийлгэсэн эрүүл мэндийн ажилтны 77.8%, 3 тун хийлгэсэн эрүүл мэндийн ажилтны 87.2% нь дархлаа тогтсон үзүүлэлттэй байна.



Дүгнэлт

- Anti-HBs нь вакцинаар өдөөдөгдсөн дархлаа тогтцыг хялбархан хэмжих үндсэн гол үзүүлэлт юм. Халдвар авахын өмнөх вакцинжуулалтын дараа anti HBs $\geq$ 10 IU/L тодорхойлогдсон хүмүүс гепатит В вирусын хурц болон архаг халдвараас бараг бүрэн хамгаалагдах ба вакцины дараа anti HBs түвшин 10 IU/L-ээс буурахад ч хамгаалалт хадгалагддаг байна.^{3,4}
- Эрүүл мэндийн ажилтны вакцинжуулалтын үрдүнд тэдний 85.83% нь гепатит В вирусын халдвараас сэргийлж чадахаар байна. Энэ судалгаа нь В гепатитын халдвараас сэргийлэхийн тулд вакциныг 3 удаагийн тунгаар хийлгэх нь чухал ач холбогдолтойг батлан харуулж байна.

Хэлцэмж

- В гепатитийн халдвараас сэргийлэх дархлаажуулалтанд хамрагдсан боловч дархлаа тогтцын шинижлгээнд хамрагдаагүй үлдсэн эрүүл мэндийн ажилтныг хамруулах, дархлаа бүрэн тогтоогүй байгаа эрүүл мэндийн ажилтныг зохих тунгаар нь дахин дархлаажуулалтанд хамруулах шаардлагатай.

Ном зүй:

- www.cdc.gov
- УХТЭ-ын эрүүл мэндийн ажилтны В дархлаажуулалтын мэдээллийн сан
- Francis DP, Hadler SC, Thompson SE, et al. The prevention of hepatitis B with vaccine: report of the Centers for Disease Control multi-center efficacy trial among homosexual men. Ann Intern Med 1982; 97:362--6.
- Hadler SC, Francis DP, Maynard JE, et al. Long-term immunogenicity and efficacy of hepatitis B vaccine in homosexual men. N Engl J Med 1986;315:209-14.

Анхаарал тавьсанд
баярлалаа